



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ
ДАНСУУД 2012 ОНД**

Улаанбаатар 2013 он

ГАРЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Үндэсний тооцооны дансууд

2.1 Үйлдвэрлэлийн данс

2.2 Орлого бүрдэлтийн данс

2.3 Анхны орлого хуваарилалтын данс

2.4 Орлогын дахин хуваарилалтын данс

2.5 Орлого ашиглалтын данс

2.6 Хөрөнгийн данс

2.7 Гадаад эдийн засгийн данс

Гурав. ҮТД-ны гол үзүүлэлтийг зарим улсуудтай харьцуулсан байдал

Дөрөв. Дүгнэлт

Нэг. ОРШИЛ

Үндэсний тооцооны дансууд нь эдийн засгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг төдийгүй тухайн орны эдийн засаг дахь үйлдвэрлэлийн хэмжээ, хүн амын бэл бэнчин, хөрөнгийн хэмжээг тодорхой хугацааны байдлаар харуулж чаддагаараа ихээхэн ач холбогдолтой.

Үндэсний тооцооны дансууд нь нэг талаас улс орны эдийн засгийн амьдралыг бүхэлд нь дүрслэн харуулахад чиглэгдсэн харилцан уялдаа бүхий үзүүлэлтүүдийн систем, нөгөө талаас эдийн засаг дахь секторууд хоорондын болон гадаад эдийн засгийн харилцааг харуулахад чиглэгдэнэ.

Үндэсний тооцооны дансанд тусгасан үзүүлэлт бүр эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг харуулах бөгөөд энэ нь нэг аж ахуйн нэгж, байгууллагын авсан, нөгөө аж ахуйн нэгж, байгууллагын өгсөн үйлдлийг харуулна. Эдгээрийг тусгах үүднээс данс нь нөөц болон ашиглалт гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нөөц талд авсныг, ашиглалт талд өгснийг харуулна. Нөөц ба ашиглалт хоёрын зөрүүг баланслуулах үзүүлэлт болно .

Дотоодын эдийн засагт үндэсний тооцооны дараах томсгосон 4 дансыг байгуулна. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн данс
2. Орлогын данс
3. Хөрөнгийн данс
4. Санхүүгийн данс

Дээрх дансуудыг дотор нь **урсгал данс, хуримтлалын данс** гэж хоёр ангилна. Үйлдвэрлэл, орлогын дансууд нь **урсгал дансыг**, хөрөнгийн болон санхүүгийн данс, түүнчлэн актив дахь бусад өөрчлөлтийн данс (туслах данс)-ыг хамтад нь **хуримтлалын данс** бүрдүүлнэ. Урсгал дансууд нь эдийн засгийн үйлдлүүд, актив, пассивын тэнцэлд шууд нөлөө үзүүлдэггүй бол хуримтлалын дансуудад тусгагдсан эдийн засгийн үйлдлүүдийн үр дүнд актив, пассивын хэмжээ, өртөг өөрчлөгдөнө.

Орлогын дансууд нь дараах 4 төрөлд хуваагдана. Үүнд:

- Орлого бүрдэлтийн данс
- Анхны орлого хуваарилалтын данс
- Орлогын дахин хуваарилалтын данс
- Орлого ашиглалтын данс

ҮСХ-ны даргын 2008 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн 01/171 тоот тушаалаар баталсан “Үндэсний тооцооны дансууд байгуулах аргачлал”-ын дагуу дансны тооцоог хийсэн.

ДНБ-ийг эдийн засгийн сектороор тооцохдоо мал аж ахуй, газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлийн гүйцэтгэлийг аж ахуйн нэгжийн болон өрхийн гэж ангилж, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийг санхүүгийн бус секторт, өрхийн үйлдвэрлэлийг өрхийн аж ахуйн секторт; албан бус секторын үйлдвэрлэлийг өрхийн аж ахуйн секторт; бодит болон хийсвэр түрээсийн тооцоог өрхийн аж ахуйн секторт тус тус орууллаа.

Үндэсний тооцооны дансуудыг дараах дарааллаар байгуулдаг.

Үндэсний тооцооны дансны хураангуй загвар

<u>Ашиглалт</u>	<u>Нөөц</u>
Үйлдвэрлэлийн данс	
Завсрын хэрэглээ	Нийт үйлдвэрлэлт (зах зээлийн үнээр) Бүтээгдэхүүний татвар, татаас
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Дотоодын бүтээгдэхүүн, <i>нийт/цэвэр</i> Гадаад урсгал гүйлгээний тэнцэл	
Орлого бүрдэлтийн данс	
Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс Бүтээгдэхүүний татвар Бүтээгдэхүүний татаас	Дотоодын бүтээгдэхүүн, <i>нийт/цэвэр</i>
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Ашиг/холимог орлого, <i>нийт/цэвэр</i>	
Анхны орлого хуваарилалтын данс	
Өмчийн орлого, өгсөн	Ашиг/холимог орлого, <i>нийт/цэвэр</i> Өмчийн орлого, авсан Цалин, түүнтэй адилтгах орлого Үйлдвэрлэлийн болон импортын татвар, татаас
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Анхны орлогын үлдэгдэл, <i>нийт/цэвэр</i> , Үндэсний орлого, <i>нийт/цэвэр</i>	
Орлогын дахин хуваарилалтын данс	
Урсгал шилжүүлгүүд, өгсөн	Анхны орлогын сальдо, <i>нийт/цэвэр</i> Урсгал шилжүүлгүүд, авсан
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Эзэмшлийн орлого, <i>нийт/цэвэр</i>	
Орлого ашиглалтын данс	
Эцсийн хэрэглээний зарлага	Эзэмшлийн орлого, <i>нийт/цэвэр</i>
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Хадгаламж, <i>нийт/ цэвэр</i>	
Хөрөнгийн данс	
Нийт үндсэн хөрөнгийн хуримтлал Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт Үнэт зүйлсийн хуримтлал Үндсэн хөрөнгийн элэгдэл Үйлдвэрлэгдээгүй санхүүгийн бус активын өсөлт (хорогдлыг хассан)	Хадгаламж, <i>нийт/ цэвэр</i> Хөрөнгийн шилжүүлгүүд, авсан Хөрөнгийн шилжүүлгүүд, өгсөн
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Цэвэр зээлжүүлэлт (+)/Цэвэр өглөг Хадгаламж, хөрөнгийн шилжүүлэгд гарсан өөрчлөлт	
Санхүүгийн данс	
Хөрөнгийн бусад өөрчлөлтийн данс	
Хөрөнгийн дахин үнэлгээний данс	
Актив, пассивийн тэнцэл	

Хоёр. ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ ДАНСУУД

Үйлдвэрлэл хэрхэн явагдаж, орлого хэрхэн бий болж, хуваарилагдаж, дахин хуваарилагдаж байгаа, түүнчлэн орлогынхоо хэдийг нь хэрэглэж, хир хэмжээтэйг хадгалж, тэрхүү хадгаламж нь юунд зарцуулагдаж байгаа зэрэг эдийн засгийн үйлдлүүдийг үндэсний тооцооны дансны нэгтгэл харуулдаг. Үндэсний тооцооны данс үйлдвэрлэл, хэрэглээ, хуримтлалыг үе шаттайгаар харуулахаас гадна, эдийн засгийн сектороор харуулна.

2.1 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАНС

Дансуудын анхдагч нь үйлдвэрлэлийн данс юм. Үйлдвэрлэлийн дансны нөөц талд үндсэн үнээр үнэлэгдсэн бараа, үйлчилгээний нийт хэмжээ буюу нийт үйлдвэрлэлийг сектороор; бүтээгдэхүүний цэвэр татварыг нийт эдийн засгийн хувьд улсын дүнгээр тусгадаг бол ашиглалт талд худалдан авагчийн үнээр тооцсон завсрын хэрэглээг тусгана.

Хүснэгт 1

Үйлдвэрлэлийн дансны нэгтгэл


(оны үнээр, тэрбум төг)

	2009	2010	2011	2012	2012 / 2011 %
Нөөц					
Нийт үйлдвэрлэл, үндсэн үнээр	12 718.1	15 085.2	20 976.0	26 405.9	125.9
Бүтээгдэхүүний татвар	608.7	1 041.0	1 745.6	1 936.2	110.9
Бүтээгдэхүүний татаас (-)	16.9	37.4	82.5	77.8	94.3
Бүгд	13 309.9	16 088.9	22 639.1	28 264.4	124.8
Ашиглалт					
Завсрын хэрэглээ	6 719.2	7 674.4	11 551.3	14 251.5	123.4
ДНБ, зах зээлийн үнээр	6 590.6	8 414.5	11 087.7	14 012.9	126.4
Бүгд	13 309.9	16 088.9	22 639.1	28 264.4	124.8

Дотоодын нийт үйлдвэрлэл оны үнээр 2012 онд 26 405.9 тэрбум төгрөгт хүрч, 2009 оноос 2.1 дахин, 2010 оноос 75.0 хувиар, 2011 оноос 25.9 хувиар өссөн байна.

Зураг1

Нийт үйлдвэрлэлийн бүтэц, эдийн засгийн сектороор, хувиар




Нийт үйлдвэрлэлийн бүтцийг эдийн засгийн секторуудаар авч үзэхэд санхүүгийн бус секторт хамгийн их буюу 70.9 хувь нь ногдож байгаа бол санхүүгийн секторт 3.0 хувь, төрийн байгууллагын секторт 8.2 хувь, өрхийн аж ахуйн секторт 17.4 хувь, ӨАА-д

үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторт 0.5 хувь ногдож байна. Үйлдвэрлэлийн дансны баланслуулах үзүүлэлт болох ДНБ-ий гүйцэтгэл 2009 оныхоос 2.1 дахин, 2010 оныхоос 66.5 хувиар, 2011 оныхоос 26.4 хувиар өсчээ.

Зураг 2

ДНБ-ий бүтэц, эдийн засгийн сектороор, хувиар, 2012 оны байдлаар



ДНБ-д санхүүгийн бус секторын эзлэх хувь 2012 онд 48.6 хувь, өрхийн аж ахуйн секторынх 24.3 хувь, бусад секторуудын эзлэх хувийн жин 0.4-9.3 хувь байгаа бол бүтээгдэхүүний цэвэр татварын эзлэх хувь 13.3 байна.

2.2 ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ДАНС

Орлого бүрдэлтийн данс нь эдийн засгийн секторуудад орлого хэрхэн бүрэлдэж бий болдгийг харуулдаг. Энэ дансны нөөцийн үзүүлэлт нь секторуудад бүтээгдсэн нэмэгдэл өртөг, ашиглалтын үзүүлэлт нь цалин хөлс, татвар, татаас, бусад татвар хураамжууд байна.

Хүснэгт 2

Орлого бүрдэлтийн дансны нэгтгэл

(оны үнээр, тэрбум төг)


	2009	2010	2011	2012	2012 / 2011 %
Нөөц					
ДНБ, зах зээлийн үнээр	6 590.6	8 414.5	11 087.7	14 012.9	126.4
Бүгд	6 590.6	8 414.5	11 087.7	14 012.9	126.4
Ашиглалт					
Ажиллагчдын цалин хөлс	1 895.8	2 122.0	2 678.3	3 896.1	145.5
Үйлдвэрлэл болон импортын татвар	1 023.3	1 805.1	1 890.6	2 112.4	111.7
Бүтээгдэхүүний татвар	608.7	1 041.0	1 745.6	1 936.2	110.9
Үйлдвэрлэлийн бусад татвар	414.7	764.2	145.0	176.2	121.5
Үйлдвэрлэл болон импортын татаас(-)	16.9	37.4	82.5	77.8	94.3
Бүтээгдэхүүний татаас (-)	16.9	37.4	82.5	77.8	94.3
Нийт ашиг ба нийт холимог орлого	3 688.4	4 524.8	6 518.9	8 082.1	124.0
Бүгд	6 590.6	8 414.5	11 087.7	14 012.9	126.4

Орлого бүрдэлтийн дансны нэг гол үзүүлэлт бол ажилчдын хөдөлмөрийн хөлс юм. Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс 2012 онд 2011 онтой харьцуулахад 45.5 хувиар өссөн байна. Үүний дотор 2011 онтой харьцуулахад өрхийн аж ахуйн секторынх 51.6 хувь, төрийн байгууллагын секторынх 51.5 хувь, өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус

байгууллагын секторынх 43.8 хувь, санхүүгийн бус секторынх 43.6 хувь, санхүүгийн секторынх хамгийн бага буюу 27.6 хувиар өсчээ.

Зураг 3

Ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний бүтэц сектороор, хувь, 2012 он



Орлого бүрдэлтийн дансны өөр нэг бүрэлдэхүүн хэсэг бол татвар юм. Бүтээгдэхүүний татвар 2012 онд 2011 оныхоос 10.9 хувиар өссөний дотор нэмэгдсэн өртгийн татвар 16.3 хувиар, онцгой албан тавар 6.3 хувиар өсч, гадаад үйл ажиллагааны татвар 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 3

Татвар ба татаас, тэрбум төгрөг

	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Бүтээгдэхүүний татвар	608.7	1 041.0	1 745.6	1 936.2	110.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	326.0	579.1	1 114.4	1 296.5	116.3
Онцгой албан татвар	166.7	268.5	294.0	312.4	106.3
Гадаад үйл ажиллагааны албан татвар	116.0	193.3	337.2	327.4	97.1
Бүтээгдэхүүний татаас	- 16.9	- 37.4	- 82.5	- 77.8	94.3
Эрчим хүч, дулааны алдагдлын татаас	- 16.9	- 36.5	- 42.9	- 37.1	86.6
Нийтийн тээврийн үйлчилгээний татаас		- 0.9	- 39.6	- 40.7	102.6
Бусад татвар (төлбөр, хураамжууд)	414.7	764.2	145.0	176.2	121.5
Өмчийн татвар	11.2	13.8	17.2	21.9	127.9
Тусгай зориулалтын орлого	16.1	17.7	26.4	23.2	87.8
Бусад татвар (төлбөр, хураамжууд)	200.9	309.5	76.9	85.8	111.5

Орлого бүрдэлтийн дансны баланслуулах үзүүлэлт болох ашиг, холимог нь зах зээлийн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны эцсийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд үндсэндээ ашиг болон төрөл бүрийн үнийн зөрүүгээс олсон орлого юм. Ашиг нь аж ахуй эрхлэгчдийн татвар төлөхийн өмнөх анхдагч ашиг байна..

Нийт ашиг, холимог орлого нь 2012 онд дүнгээрээ 8 082.1 тэрбум төгрөг болж 2011 оныхоос 22.4 хувь нэмэгджээ. Эдийн засгийн секторуудаар авч үзэхэд санхүүгийн бус секторынх 13.3 хувиар, санхүүгийн секторынх 64.9 хувиар, өрхийн аж ахуйн секторынх 31.6 хувиар, өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторынх 2.6 дахин өссөн байна.

Ашиг/холимог орлого,
эдийн засгийн сектороор, оны үнээр, тэрбум төгрөг

	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Санхүүгийн бус сектор	1 701.0	2 434.8	3 796.7	4 300.6	113.3
Санхүүгийн сектор	91.2	147.7	246.4	406.4	164.9
Төрийн байгууллагын сектор	15.3	- 0.5	-	-	-
Өрхийн аж ахуйн сектор	1 878.6	1 940.5	2 552.6	3 360.3	131.6
ӨАА-д үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор	2.4	2.2	5.7	14.8	260.0
Дотоод эдийн засгийн дүн*	3 688.4	4 524.8	6 601.4	8 082.1	122.4

*Ашигт малтмалын нөөц ашигласантай холбогдох зардлууд анхны орлого хуваарилалтын дансны өмчийн орлогын хэсэгт тусгагдсан тул ашиг холимог орлогын дүн нь ДНБ-ны тооцооныхоос зөрүүтэй байгаа болно.

2.3 АНХНЫ ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТЫН ДАНС

Анхны орлогын хуваарилалтын данс нь нийт эдийн засгийн хувьд (дотоод болон гадаад эдийн засгийн секторын хэмжээнд) анхны орлогын дүн түүний хуваарилалтыг харуулна. Энэхүү дансны баланслуулах үзүүлэлт нь секторуудын хувьд анхны орлогын үлдэгдэл, нийт эдийн засгийн хувьд үндэсний орлого байна.

Хүснэгт 5

Анхны орлогын хуваарилалтын дансны нэгтгэл
(оны үнээр, тэрбум төг)

	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Нөөц					
Нийт ашиг ба нийт холимог орлого	3 688.4	4 524.8	6 360.7	8 082.1	127.1
Ажиллагчдын цалин хөлс	1 890.1	2 082.9	2 532.3	3 565.2	140.8
Үйлдвэрлэл, импортын татвар	1 023.3	1 805.1	2 131.2	2 112.4	99.1
Үйлдвэрлэл, импортын татаас (-)	16.9	37.4	82.5	77.8	94.3
<i>Өмчийн орлого /хүлээн авсан/</i>	1 051.7	660.5	2 025.3	2 142.9	105.8
Бүгд	7 636.7	9 036.0	12 967.0	15 824.9	122.0
Ашиглалт					
<i>Өмчийн орлого /төлсөн/</i>	1 327.6	1 381.6	2 946.5	3 100.8	105.2
Анхны орлогын үлдэгдэл /Үндэсний нийт орлого	6 309.1	7 654.4	10 020.5	12 724.1	127.0
Бүгд	7 636.7	9 036.0	12 967.0	15 824.9	122.0

Анхны орлогын хуваарилалтын дансны чухал үзүүлэлтийн нэг болох өмчийн орлого нь материаллаг баялаг үйлдвэрлэхэд оролцдоггүй, биет хөрөнгө болон санхүүгийн хөрөнгийг бусдад ашиглуулсны төлөө тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа эзэмшигчийн авч байгаа орлого юм. Өмчийн орлогод хүү, ногдол ашиг, газар болон газрын доорх ашигт малтмалыг бусдад эзэмшүүлсний төлөө авч байгаа түрээсийн орлого зэрэг болно.

Үндэсний нийт орлого 2012 онд 12 724.1 тэрбум төгрөг болж, 2011 оныхоос 27.0 хувь буюу 2 703.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

Анхны орлогын үлдэгдэл/үндэсний орлогод секторуудын оролцоо ямар байгааг авч үзье.

Хүснэгт 6

Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний нийт орлого,
эдийн засгийн сектороор, оны үнээр, тэрбум төгрөг

Он		Санхүүгийн бус сектор	Санхүүгийн сектор	Төрийн байгууллагын сектор	Өрхийн аж ахуйн сектор	ӨАА-д үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор	Нийт эдийн засгийн дүн
2010	Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний нийт орлого	2 309.3	147.7	1 083.7	4 110.9	2.9	7 654.5
	хувь	30.2	1.9	14.2	53.7	0.0	100.0
2011	Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний нийт орлого	3 384.2	157.5	1 308.1	5 165.1	5.5	10 020.5
	хувь	33.8	1.6	13.1	51.5	0.1	100.0
2012	Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний нийт орлого	3 791.5	310.6	1 594.7	7 012.7	14.6	12 724.1
	хувь	29.8	2.4	12.5	55.1	0.1	100.0

Анхны орлогын үлдэгдэл буюу үндэсний нийт орлогын талаас илүү буюу 55.1 хувь нь өрхийн аж ахуйн секторт ногдож байна. Энэ нь бусад секторуудаас олгож буй ажиллагчдын хөдөлмөрийн хөлс нь уг секторын орлогын үндсэн эх үүсвэр болдогтой холбоотой. Анхны орлогын үлдэгдэл 2012 оны байдлаар санхүүгийн бус секторт 29.8 хувь, төрийн байгууллагын секторт 12.5 хувь, санхүүгийн секторт 2.4 хувь байна. Татвар нь улсын нэгдсэн төсвийн үндсэн орлого учраас анхны орлогод төрийн байгууллагын эзлэх хувь харьцангуй өндөр жинтэй байдаг байна.

2.4 ОРЛОГЫН ДАХИН ХУВААРИЛАЛТЫН ДАНС

Орлогын дахин хуваарилалтын данс нь анхны орлогын үлдэгдэл урсгал шилжүүлгийн дүнд хэрхэн эзэмшлийн орлого болж хувирахыг харуулна. Шилжүүлэг нь эдийн засгийн нэг сектор нөгөө сектортоо ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа, бараа үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө байна. Шилжүүлгийг дотор нь урсгал болон хөрөнгийн гэж хоёр хуваадаг. Урсгал шилжүүлэг нь орлогын болон хөрөнгийн урсгал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, бусад урсгал шилжүүлгүүдээс бүрдэнэ.

2012 онд эзэмшлийн нийт орлого 13 049.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос 26.4 хувиар өссөн байна. Эзэмшлийн нийт орлого нь үндэсний нийт орлогоос илүү байгаа нь манай улсад Засгийн газар хоорондын урсгал шилжүүлэг, олон улсын хамтын ажиллагааны хүрээний болон төрийн бус байгууллагын урсгал шилжүүлэг гаднаас их хэмжээгээр орж ирсэнтэй холбоотой байна.

Орлогын дахин хуваарилалтын дансны нэгтгэл
(оны үнээр, тэрбум төг)

	2009	2010	2011	2012	2012 2011 %
Нөөц					
Үндэсний нийт орлого	6 309.1	7 654.4	10 020.5	12 724.1	127.0
Урсгал шилжүүлэг	421.1	378.5	1 362.2	1 436.7	105.5
Бүгд	6 730.2	8 032.9	11 382.7	14 160.8	124.4
Ашиглалт					
Урсгал шилжүүлэг	153.6	176.8	1 060.8	1 111.3	104.8
Эзэмшлийн нийт орлого	6 576.6	7 856.1	10 321.9	13 049.5	126.4
Бүгд	6 730.2	8 032.9	11 382.7	14 160.8	124.4

Орлогын дахин хуваарилалтын дансны дүнгээс үзвэл (хүснэгт 8) улсын нэгдсэн төсөвт оруулсан орлогын болон хөрөнгийн татвар 2011 онд 1 011.5 тэрбум төгрөг байсан бол 2012 онд 1 034.4 тэрбум төгрөг болж 2.3 хувиар өсчээ. Энэ нь бараа, бүтээгдэхүүний татвар 10.0 орчим хувиар өссөнтэй холбоотой байна. 2012 оны байдлаар орлого болон хөрөнгийн татварын 62.6 хувийг санхүүгийн бус сектор, 33.5 хувийг өрхийн аж ахуйн сектор, 3.8 хувийг санхүүгийн сектор бүрдүүлжээ.

Өрхийн аж ахуйн сектороос нийгмийн даатгалын шимтгэлд 388.6 тэрбум төгрөг төлж, төрөөс 1018.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авсан нь 2011 оныхоос 390.5 тэрбум төгрөгөөр илүү байна.

Орлогын дахин хуваарилалтын дансны үзүүлэлтүүд, сектороор, тэрбум төгрөг

Үзүүлэлт	Санхүүгийн бус сектор	Санхүүгийн сектор	Төрийн байгууллагын сектор	Өрхийн аж ахуйн сектор	ӨАА-д үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор	Нийт эдийн засгийн дүн
Анхны орлогын үлдэгдэл/үндэсний орлого, нийт	3791.5	310.6	1594.7	7012.7	14.6	12724.1
Орлогын ба хөрөнгийн татвар	авсан		1034.4			1034.4
	өгсөн	647.6	39.7	347.0		1034.4
Нийгмийн даатгалын шимтгэл	авсан	-267.4	-18.2	674.2		388.6
	өгсөн			388.6		388.6
Нийгмийн халамжийн тэтгэмж	авсан			1018.6		1018.6
	өгсөн			1018.6		1018.6
Урсгал шилжүүлэг	авсан	7.3	27.9	150.7	994.5	256.3
	өгсөн	79.3	12.4	986.6	8.1	24.9
Эзэмшлийн орлого, нийт	2804.5	268.2	1448.8	8282.0	246.0	13049.5
Секторуудын хувийн жин	29.8	2.4	12.5	55.1	0.1	100.0

Эзэмшлийн нийт орлогод өрхийн аж ахуйн секторын эзлэх хувь 55.1 хувь, төрийн байгууллагын секторынх 12.5 хувь, санхүүгийн бус секторынх 29.8 хувь байна.

2.5 ОРЛОГО АШИГЛАЛТЫН ДАНС

Орлого ашиглалтын дансаар секторуудын эзэмшлийн орлого нь эцсийн хэрэглээ болон хуримтлалд хэрхэн ашиглагдав гэдгийг харуулж, орлогын дансны эцсийн үр дүнг тодорхойлно. Баланслуулах үзүүлэлт нь хадгаламж байна.

Хүснэгт 9

Орлого ашиглалтын дансны нэгтгэл

(оны үнээр, тэрбум төг)

	2009	2010	2011	2012	2012 2011 %
Нөөц					
Эзэмшлийн нийт орлого	6 576.6	7 856.1	10 321.9	13 049.5	126.4
Бүгд	6 576.6	7 856.1	10 321.9	13 049.5	126.4
Ашиглалт					
Эцсийн хэрэглээний зардал	4 781.5	5 670.8	6 953.6	9 367.7	134.7
<i>Хувийн хэрэглээний зардал</i>	4 327.1	5 103.8	6 308.2	8 123.1	128.8
<i>Хамтын хэрэглээний зардал</i>	454.4	567.0	645.3	1 244.6	192.9
Нийт хадгаламж	1 795.1	2 185.3	3 368.3	3 681.8	109.3
Цэвэр хадгаламж	1 327.7	1 695.2	2 767.1	2 859.3	103.3
Бүгд	6 576.6	7 856.1	10 321.9	13 049.5	126.4

Улсын хэмжээгээр 2012 онд эзэмшлийн нийт орлогын 71.8 хувийг эцсийн хэрэглээнд зарцуулсан байна.

Хадгаламж, эдийн засгийн сектороор

(оны үнээр, тэрбум төг)

Үзүүлэлт	Санхүүгийн бус сектор	Санхүүгийн сектор	Төрийн байгууллагын сектор	Өрхийн аж ахуйн сектор	ӨАА-д үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор	Нийт эдийн засгийн дүн
Эзэмшлийн орлого, нийт	2 804.5	268.2	1 448.8	8 282.0	246.0	13 049.5
Эзэмшлийн орлого, цэвэр	2 025.9	231.0	1 448.8	8 278.4	242.9	12 227.0
Эцсийн хэрэглээний зардал			1 895.5	7 392.8	79.4	9 367.7
Эзэмшлийн нийт орлогод эцсийн хэрэглээний зардлын эзлэх хувь			130.8	89.3	32.3	71.8
Хадгаламж, нийт	2 804.5	268.2	- 446.6	889.2	166.6	3 681.8
Хадгаламж, цэвэр	2 025.9	231.0	- 446.6	885.6	163.5	2 859.3
Цэвэр хадгаламжид секторуудын эзлэх хувь	70.9	8.1	-15.6	31.0	5.7	100.0

2012 оны байдлаар нийт хадгаламжид санхүүгийн бус секторын эзлэх хувийн жин 70.9 хувь, өрхийн аж ахуйн секторт 31.0 хувь, санхүүгийн сектор 8.1 хувь, ӨААд үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторт 5.7 хувь нь ногдож байгаа бол төрийн байгууллагын сектор сөрөг хадгаламжтай буюу эзэлтэй байгаа нь харагдаж байна.

2.6 ХӨРӨНГИЙН ДАНС

Орлогын дансуудын дараа байгуулдаг данс бол хөрөнгийн данс юм. Энэ данс нь үндсэн болон эргэлтийн хөрөнгө, үйлдвэрлэгдээгүй санхүүгийн бус хөрөнгийн хуримтлал, тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийг харуулдаг.

Хүснэгт 11

Хөрөнгийн дансны нэгтгэл

(оны үнээр, тэрбум төг)

	2009	2010	2011	2012	<u>2012</u> <u>2011</u> %
Пассив болон хөрөнгийн өөрчлөлт					
Хадгаламж, цэвэр	1 327.7	1 695.2	2 767.1	2 859.3	103.3
Хөрөнгийн шилжүүлгүүд, авсан (+)	496.5	445.1	1 214.2	1 297.5	106.9
Хөрөнгийн шилжүүлгүүд, өгсөн (-)	727.7	651.5	- 1 062.3	- 1 133.8	106.7
статистик зөрүү	- 22.2	45.1	1 458.1	1 602.6	109.9
Бүгд	1 536.7	1 946.7	4 377.1	4 625.6	
Активын өөрчлөлт					
Үндсэн хөрөнгийн хуримтлал, цэвэр	1 436.6	2 248.2	6 329.6	8 026.3	126.8
Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөцийн өөрчлөлт	361.3	694.2	1 458.1	1 602.6	109.9
Үнэт зүйлсийн нөөцийн өөрчлөлт	0.0	0.1	.0	.0	100.0
Цэвэр зээлжүүлэлт(+)/ цэвэр өглөг(-), статистик зөрүү	- 261.2	- 995.9	- 3 410.6	- 5 003.4	146.7
Бүгд	1 536.7	1 946.7	4 377.1	4 625.6	105.7

Хөрөнгийн шилжүүлгийн авсан хэмжээ нь 2012 онд өмнөх оноос 6.9 хувиар, хөрөнгийн шилжүүлгийн өгсөн хэмжээ нь 6.7 хувиар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн цэвэр хуримтлал өмнөх оноос 26.8 хувиар, материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөцийн өөрчлөлт 9.9 хувиар өссөн байна. Түүнчлэн цэвэр өглөгийн хэмжээ 46.7 хувиар нэмэгджээ.

2.1 ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ДАНС

Гадаад эдийн засгийн данс нь тухайн улс орны бусад улсуудтай хийсэн эдийн засгийн харилцааг нэгтгэн харуулна. Гадаад эдийн засгийн дансыг тусад нь байгуулахад 3 бүлэг данс буюу бараа, үйлчилгээний данс, анхны орлого, урсгал шилжүүлгийн данс болон хөрөнгийн дансуудаас бүрдэнэ.

Бараа, үйлчилгээний данс 3 739.6 тэрбум төгрөг, анхны орлого урсгал шилжүүлгийн данс 6 222.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан, мөн манай улсад орж ирж буй хөрөнгийн шилжүүлэг их хэмжээгээр өссөн зэрэг нь хөрөнгийн дансны тэнцлийн алдагдал нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Гадаад эдийн засгийн данс 2009-2012 оны гүйцэтгэл,
(оны үнээр, тэрбум төгрөг)

	2009	2010	2011	2012	$\frac{2012}{2011}$ %
Бараа, үйлчилгээний данс					
		Ашиглалт			
Бараа, үйлчилгээний экспорт	3 313.6	4 602.7	6 912.3	7 084.6	102.5
Бараа	2 716.4	3 943.7	6 124.3	5 778.0	94.3
Үйлчилгээ	597.3	659.0	788.0	1 306.6	165.8
		Нөөц			
Бараа, үйлчилгээний импорт	3 792.0	5 246.6	9 628.5	10 824.2	112.4
Бараа	2 988.4	4 188.3	7 364.3	8 023.1	108.9
Үйлчилгээ	803.6	1 058.3	2 264.2	2 801.1	123.7
Гадаад худалдааны сальдо	- 478.3	- 643.9	- 2 716.2	- 3 739.6	137.7
Анхны орлого, урсгал шилжүүлгийн данс					
		Ашиглалт			
Гадаад худалдааны сальдо	- 478.3	- 643.9	- 2 716.2	- 3 739.6	137.7
Ажиллагчдын цалин хөлс	11.7	24.8	38.1	46.4	121.8
Өмчийн орлого	23.3	14.4	17.2	31.3	181.7
Хүү	23.3	14.4	17.2	31.3	181.7
Урсгал шилжүүлэг	375.0	416.5	572.5	682.1	119.1
Засгийн газар хоорондын урсгал шилжүүлэг	89.6	44.5	35.9	55.6	154.6
Ажиллагчдын гуйвуулга	275.9	336.2	315.5	389.1	123.3
Бусад урсгал шилжүүлэг	9.5	35.8	221.1	237.5	107.4
		Нөөц			
Ажиллагчдын цалин хөлс	17.4	68.6	184.1	377.4	205.0
Өмчийн орлого	299.2	740.9	938.4	989.2	105.4
Хүү	299.2	782.7	938.4	989.2	105.4
Урсгал шилжүүлэг	107.5	214.9	271.1	356.7	131.6
Засгийн газар хоорондын урсгал шилжүүлэг	3.8	2.9	13.5	5.9	43.8
Ажиллагчдын гуйвуулга	102.8	160.7	241.5	333.4	138.1
Бусад урсгал шилжүүлэг	0.8	51.3	16.2	17.4	107.5
Сальдо	- 1 312.5	- 2 123.9	- 4 737.8	- 6 222.7	131.3
Хөрөнгийн данс					
		Ашиглалт			
Сальдо	- 1 312.5	- 2 123.9	- 4 737.8	- 6 222.7	131.3
Хөрөнгийн шилжүүлгүүд, авсан /+/	77.5	1.4	3.9	3.0	75.6
		Нөөц			
Хөрөнгийн шилжүүлгүүд, өгсөн /-/	898.5	207.1	147.9	166.7	112.7
Цэвэр зээлжүүлэлт (+)/ цэвэр өглөг (-)	- 2 133.5	- 2 329.6	- 4 881.8	- 6 386.4	130.8

Гурав. Үндэсний тооцооны дансны гол үзүүлэлтүүдийг зарим улс орнуудтай харьцуулсан байдал

НҮБ-ын Статистикийн хэлтсээс гишүүн орнуудынхаа үндэсний тооцооны үзүүлэлтүүдийг 1998 оноос хойш эмхтгэн гаргаж байна.

Уг эмхтгэлийн мэдээллийг ашиглан Казахстан, Япон, Герман, Украин, БНСУ зэрэг улсуудтай харьцуулсан үндэсний тооцооны дансны гол үзүүлэлтүүдийн секторын бүтцийг өөрийн орны дансны үзүүлэлттэй харьцуулан авч үзлээ. Улс орнуудыг сонгохдоо өндөр хөгжилтэй (Япон, Герман, Солонгос), хөгжиж байгаа (Украин), өөрийн оронтой ижил төстэй (Казахстан) улсуудыг авч үзсэн болно.

Нийт үйлдвэрлэлийн эдийн засгийн секторын бүтцийг авч үзэхэд 70 аас дээш хувь нь санхүүгийн секторт, 10 гаруй хувь нь өрхийн аж ахуйн секторт ногдож байна.

Харин ДНБ-ий хувьд Казахстангаас бусад улсуудад 50-аас дээш хувь нь санхүүгийн бус секторт ногдож байна. Манай орны хувьд ч энэ хандлага ажиглагдаж байна.

Ашиг, холимог орлогын диилэнх нь буюу 50-аас дээш хувь нь санхүүгийн бус секторт ногдож байна. Харин Казахстан, Герман улсуудад энэ үзүүлэлт 80 орчим хувьтай байна.

Үндэсний нийт орлогын хувь ихэнх орнуудын хувьд өрхийн аж ахуйн секторт дийлэнх нь ногдож байна. Харин санхүүгийн бус секторт 10-30 орчим хувьтай байна.

Эзэмшлийн орлогыг секторуудаар авч үзэхэд 50-60 хувь нь өрхийн аж ахуйн секторт 20 гаруй хувь нь төрийн байгууллагын секторт 10 гаруй хувь нь санхүүгийн бус секторт ногдож байна.

Нийт хадгаламжийн эдийн засгийн секторуудээрх бүтэц харилцан адилгүй байна. Казахстан, Япон орнуудын хувь санхүүгийн бус секторт өндөр байгаа бол Герман улсын хувьд өрхийн аж ахуйн сектор, санхүүгийн бус секторт ижилхэн 40 гаруй хувьтай байна.

Манай улсын хувьд Санхүүгийн секторт дийлэнх нь буюу 70 гаруй хувь нь, өрхийн аж ахуйн секторт 30 орчим хувь нь ногдож байна.

Хүснэгт 13-т эдийн засгийн сектороор дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Үндэсний тооцооны дансны зарим үзүүлэлтүүдийн бүтэц, хувиар

	Санхүүгийн бус сектор	Санхүүгийн сектор	Төрийн байгууллагын сектор	Өрхийн аж ахуйн сектор	ӨАА-д үйлчилдэг ашигийн бус байгууллагын сектор
Нийт үйлдвэрлэлт, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	77.0	3.8	4.9	13.9	0.4
Герман	71.7	4.4	6.8	17.4	-
Украйн	75.0	4.4	8.7	11.5	0.4
Солонгос	74.6	4.5	5.4	-	-
Монгол*	70.9	3.0	8.2	17.4	0.5
Завсрын хэрэглээ, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	81.4	1.9	5.6	10.8	0.3
Герман	78.6	5.3	4.4	11.6	-
Украйн	82.7	1.9	4.4	7.8	0.2
Солонгос	84.0	3.1	2.5	-	-
Монгол*	83.6	1.5	6.0	8.3	0.5
Дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	71.4	5.3	4.2	16.3	0.5
Герман	57.3	3.1	8.3	21.1	-
Украйн	55.2	7.2	13.2	14.8	0.4
Солонгос	51.4	6.3	9.6	-	-
Монгол*	48.6	4.1	9.3	24.3	0.4
Ашиг, холимог орлого, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	89.3	9.2	1.9	-	0.0
Япон	66.6	(0.9)	9.0	24.3	0.9
Герман	79.1	2.0	4.8	0.0	-
Украйн	58.8	11.5	2.8	36.7	0.3
Солонгос	54.4	8.8	5.1	-	-
Монгол*	53.2	5.0	-	41.6	0.2
Үндэсний нийт орлого, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	28.5	10.2	11.8	55.0	0.0
Япон	19.9	3.6	10.1	64.3	0.4
Герман	11.5	1.2	10.6	76.7	-
Украйн	13.7	5.0	15.2	66.0	0.1
Солонгос	16.8	3.6	14.7	61.0	-
Монгол*	29.8	2.4	12.5	55.1	0.1
Эзэмшлийн орлого, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	22.1	5.4	21.7	50.8	0.0
Япон	16.5	3.1	17.6	64.4	1.8
Герман	10.2	1.6	20.5	67.2	-
Украйн	8.2	4.5	20.0	66.5	0.8
Солонгос	13.3	3.0	23.7	56.8	-
Монгол*	21.5	2.1	11.1	63.5	1.9
Нийт хадгаламж, эдийн засгийн сектороор, хувиар					
Казакстан	60.3	15.1	26.4	0.5	(2.3)
Япон	62.9	12.1	0.8	21.6	2.5
Герман	40.1	1.9	9.8	46.9	-
Украйн	39.5	21.9	11.3	27.1	0.3
Солонгос	45.1	10.0	30.5	13.9	-
Монгол*	76.2	7.3	-	24.2	4.5

Эх сурвалж: National Accounts Statistics: Main aggregates and Detailed tables, 2009, UN

* Үндэсний Статистикийн Хорооны тооцоо

Дөрөв. ДҮГНЭЛТ

Улс орны эдийн засаг нь хөгжлийн түвшнээс үл хамаарч үйлдвэрлэл-хэрэглээ-хуримтлал гэсэн гурван үндсэн шатаас бүрддэг. Эдгээр шат бүр дэх өөрчлөлтүүдийг үндэсний тооцооны дансуудын үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр харуулна.

Манай улсын 2012 онд шинээр бий болсон нэмэгдэл өртөг буюу ДНБ-ий гүйцэтгэл 2009 оныхоос 2.1 дахин, 2010 оныхоос 66.5 хувиар, 2011 оныхоос 26.4 хувиар өндөр байлаа. ДНБ-д санхүүгийн бус сектор, өрхийн аж ахуйн секторын эзлэх хувь давамгайлж байгаа нь нэмэгдэл өртгийг үндсэндээ үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бий болгож байгааг харуулж байна.

Нийт ашиг, холимог орлого нь эдийн засгийн нийт дүнгээр 2012 онд 8 082.1 тэрбум төгрөг болж 2011 оныхоос 24.0 хувь нэмэгджээ. Эдийн засгийн секторуудын хувьд авч үзэхэд санхүүгийн бус секторынх 13.30 хувиар, санхүүгийн секторынх 64.9 хувиар, өрхийн аж ахуйн секторынх 31.6 хувиар, өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторынх 2.6 дахин өссөн байна.

Үндэсний нийт орлого 2012 онд 12 724.1 тэрбум төгрөг болж, 2011 оныхоос 27.0 хувь буюу 2 703.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

Анхны орлогын үлдэгдэл буюу үндэсний нийт орлогын дийлэнх хувь нь өрхийн аж ахуйн секторт ногдож байгаа нь ажиллагчдын хөдөлмөрийн хөлс өрхийн аж ахуйн секторт орлогын эх үүсвэр болон очдогтой холбоотой байна.

Улсын нэгдсэн төсөвт оруулсан орлогын болон хөрөнгийн татвар 2011 онд 1 011.5 тэрбум төгрөг байсан бол 2012 онд 1 034.4 тэрбум төгрөг болж 2.5 хувиар өсчээ. 2012 оны байдлаар орлого болон хөрөнгийн татварын 59.7 хувийг санхүүгийн бус сектор, 33.5 хувийг өрхийн аж ахуйн секторт, 3.8 хувийг санхүүгийн сектор бүрдүүлжээ.

Өрхийн аж ахуйн сектороос нийгмийн даатгалын шимтгэлд 388.6 тэрбум төгрөг төлж, төрөөс 1018.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж авсан нь 2011 оныхоос 390.6 тэрбум төгрөгөөр илүү байна.

Манай улсад 2012 онд 2 859.3 тэрбум төгрөгийн цэвэр хадгаламж бий болсны 70.9 хувь нь санхүүгийн бус секторт, 31.0 хувь нь өрхийн аж ахуйн секторт, 8.1 хувь нь санхүүгийн секторт бий болжээ.

Аж ахуйн нэгжүүдээс хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээлэл байхгүй нь анхны орлогын хуваарилалтын дансыг байгуулахад бэрхшээл учруулж байна. Мөн санхүүгийн секторын хувьд хүүгийн орлого, зардал, ногдол ашиг газрын төлбөр зэрэг үзүүлэлтийн бүрдэлт дутуу байгаа нь анхны орлогын хуваарилалтын дансны өмчийн орлогыг тооцоход хүндрэлтэй байсан. Иймд цаашид эдийн засгийн салбаруудын жилийн эцсийн мэдээний нэгтгэлд орж байгаа хүүгийн орлого, зардал, ногдол ашиг зэрэг үзүүлэлтүүдийн хамралтийг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн одоогийн мөрдөж байгаа аргачлалыг ҮТС-2008–д нийцүүлэн шинэчлэх ажил хийгдэж байна. 2010 оны нөөц ашиглалтын хүснэгтийн үр дүнд суурилан шинэ зөвлөмжийн дагуу үндэсний тооцооны дансуудын динамикийг шинэчлэн 2014 оноос тархаахаар бэлтгэж байна.

МЭЗСГ